



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2010 оны 11 сарын 09 өдөр

Дугаар 23


Улаанбаатар хот

Г **ЛАБОРАТОРИЙН БАЙР ТҮРЭЭСЛЭХ** Т
ТУХАЙ

Монгол Улсын “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17.1.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны “ЖАЙКА” байгууллага хоорондын 2009 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хамтран ажиллах санамж бичгийн хавсралт 5.1-д заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдэх хаягдал утааны хийн найрлагад хэмжилт хийх лабораторийн байрыг бэлдэх үүргийг хамтрагч тал болох манай алба хүлээсэн. Иймд дээрхи зорилгоор “Гутал” ХХК-ны 4 давхрын 402 тоот 40м² бүхий өрөөг түрээслэн ажиллуулсугай.

Хоёр. Уг лабораторийн байрны түрээсийн зардлыг албаны батлагдсан төсөвт багтаан холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа / -д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХЦОГ

